



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас: 7000 7734, Факс: (976-11) 32 01 54,
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2021.03.29 № 777

танай _____-ны № _____-т

НИЙСЛЭЛИЙН БАЯНЗҮРХ ДҮҮРГИЙН
ЗАСАГ ДАРГА, ТӨСВИЙН
ТӨВЛӨРҮҮЛЭН ЗАХИРАГЧ
Н.БАЯРМӨНХ ТАНАА

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Хязгаарлалттай санал дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа зөрчлийн үр нөлөөг эс тооцвол Нийслэлийн Баянзүрх дүүргийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Дүүргийн удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Дүүргийн Засаг даргын (2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилт) жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 5 зорилтын хүрээнд 50 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 80.0 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Аудитын гол асуудал

Дүүргийн ИТХ-аар хөрөнгө оруулалтын төсөвт урсгал зардлын шинж чанартай ажлыг оруулан батлуулж, зарцуулсан, хот тохижилтын зардлыг дүүргийн орон нутгийн өмчтэй тохижилт үйлчилгээний дөрвөн ААН-ийн үйл ажиллагаанд баталж, санхүүжүүлсэн боловч хөрөнгө оруулалтын төсөвт нэмж хөрөнгө батлан тендер зарлан гүйцэтгүүлж төсвийн хөрөнгийг үрэлгэн зарцуулсан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн үйл ажиллагаатай холбоотой зардлын төсвийг батлуулалгүй санхүүжүүлсэн, уг санхүүжилтийг хяналтгүйгээр олгосон, нэг ижил төрлийн бараа, ажил үйлчилгээг худалдан авахдаа үнийн судалгаа, харьцуулалтын арга хэрэглээгүй, дүүргийн ахмадын хороо /төрийн бус байгууллага/ нь санхүүгийн баримтуудыг аудитад ирүүлээгүй, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдэд тушаал шийдвэргүйгээр цалин хөлсийг давхардуулан олгосон, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажилд зарцуулах зардлыг хэтрүүлэн зарцуулсан, албан хаагчдад нэг удаагийн буцалтгүй тусламж дэмжлэгийг байгууллагын дотоод журамд заасан шалгуур үзүүлэлтээр дүгнээгүй, мөнгөн дүнг тусгалгүйгээр харилцан адилгүй, давхардуулан олгосон, цахим “И” баримтын бүрдэл хангаагүй, анхан шатны бүрдэл дутуу баримтаар гүйлгээ хийсэн зэрэг нийт 11,418,828.6 мянган төгрөгийн ажил гүйлгээ хийж бүртгэлд тусгасан нь Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль болон бусад холбогдох эрх зүйн акт, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарттай нийцэхгүй, санхүүгийн тайлангийн “үнэн зөв байдал” “эрх ба үүрэг” батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн төвлөрүүлэн захирагч санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн нэгтгэсэн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн нэгтгэсэн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА БӨГӨӨД ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОРЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ



М.ЭРДЭНЭЖАРГАЛ